



НИЙСЛЭЛИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



АГУУЛГА

1. Өмнөх үг

2. Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв

- 2.1. Эрхэм зорилго
- 2.2. Хөгжлийн замнал
- 2.3. Үйл ажиллагаа явуулах эрх зүйн суурь орчин

3. НХНХТ-ийн үйл ажиллагааны хөгжил

- 3.1. НХНХТ-ийн үйл ажиллагаа 2021, тоогоор
- 3.2. НХНХТ-ийн 2021 оны гол үр дүн
- 3.3. Сургалтын үйл ажиллагаа
- 3.4. Сургалтын агуулга хөгжүүлэлт
- 3.5. Сургалтын арга
- 3.6. Хөгжлийн зураглал
- 3.7. Хүний нөөцийн хөгжил
- 3.8. Санхүүжилт
- 3.9. Хамтын ажиллагаа

4. 2022 онд хүлээгдэж буй үр дүн

Товчилсон нэрсийн жагсаалт

ББМТ	Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ННЗБ	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НССТ	Нийслэлийн Сургалт, судалгааны төв
НХНХТ	Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв
ОНЗЗН	Орон нутгийн засаг захиргааны нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУШХБ	Олон улсын Шилжилт хөдөлгөөний байгууллага
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
ХСАЗ	Харилцан суралцах арга зүй
ХЗСТ	Хотын засаглал сайжруулах төсөл
ЧБХ	Чадавх бэхжүүлэх хөтөлбөр
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг

ӨМНӨХ ҮГ



Нийгэм, эдийн засгийн тогтолцоо хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж, шинэ сорилтуудтай нүүр тулж байгаа өнөө үед төрийн албан хаагчид өргөн мэдлэгтэй, өндөр ур чадвартай, зөв хандлагатай, өөрийгөө байнга хөгжүүлдэг, шинэ нөхцөлд дасан зохицох чадвартай байх шаардлага бидний өмнө тулгарч байна.

Иймээс ч Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Нийслэлийн Сургалт, судалгааны төвийг 2017 онд байгуулж, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх, чирэгдэлгүй төрийн үйлчилгээг бий болгохын тулд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ур чадвар, чадавхыг нэгдсэн цогц бодлогоор

байнга, давтамжтай дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж, амжилттай хэрэгжүүлж байна. Энэ оноос Сургалт, судалгааны төв нь “Хүний нөөцийн хөгжлийн төв” болгон өөрчлөгдөж, үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллаж байна.

Өнгөрсөн 2 жилийн турш Коронавирусын халдвар дэлхий даяар тархаж, цар тахлын хэмжээнд хүрсний улмаас хүн төрөлхтөн өмнө байгаагүй сорилттой нүүр тулж, хэцүү цаг үеийг туулж байна. Цар тахлын улмаас танхимын сургалтын үйл ажиллагаа явагдах боломжгүй байсан хэдий ч Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв нь үүссэн нөхцөл байдалд хурдацтай дасан зохицож, цахим сургалтын платформыг хөгжүүлэх, сургалтын агуулгуудыг цахим хэлбэрт хөрвүүлэх, цахим сургалтуудыг зохион байгуулах, ажлын байран дээр чиглүүлэн сургах болон харилцан суралцах арга зүйг ашиглан албан хаагчдыг сургах, хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулж ирлээ. Цаг үеийн нөхцөл байдлаас үл хамааран 2021 онд нийт 311 удаагийн сургалтад 6692 албан хаагчийг хамруулжээ. Түүнчлэн албан хаагчдын сургалтын хэрэгцээнд үндэслэн шинээр 6 төрлийн сургалтын агуулга, гарын авлагыг боловсруулав.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв нь 2021 онд Чанарын бодлого, зорилтоо тодорхойлж, холбогдох журмуудыг боловсруулан хэрэгжүүлж үйл ажиллагаандаа Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 стандарт, Чанарын

менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэгч байгууллага болж гэрчилгээгээ гардан авсан.

Үүний зэрэгцээ төрийн үйлчилгээний анхан шатны нэгж болох хорооны албан хаагчдын сургалтад Харилцан суралцах арга зүйг нэвтрүүлж, сургалтын гарын авлагыг хэвлэн гаргалаа. Нийслэлийн хэмжээнд “Харилцан суралцах арга зүйн платформын нээлтийн ажиллагаа”-г онлайнаар амжилттай зохион байгуулж, 2020 онд тодорхойлсон 144 сайн туршлагыг Харилцан суралцах арга зүйн платформд байршуулж хороодын албан хаагчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран харилцан суралцах боломжийг бий болголоо. Улмаар Харилцан суралцах арга зүйн “Шилдэг хороо”-г шалгаруулах уралдааныг зохион байгуулах санал санаачилга гарган ажиллаж байна.

Мөн Хүний нөөцийн хөгжлийн төв нь 2021 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын хандлага, идэвх санаачилгыг сайжруулах зорилгоор “Мэтгэлцээний анхдугаар тэмцээн”-г амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн төвийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын анги танхимыг нэмэгдүүлэх, дотоод систем хөгжүүлэх, тоног төхөөрөмжийг сайжруулах, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр томоохон ажлуудыг амжилттай хийж хэрэгжүүлсэн.

Ийнхүү Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн хувьд 2021 он нь тасралтгүй суралцаж хөгжсөн, сорилт бэрхшээлийг

үр дүнтэйгээр даван туулсан, харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн, чадавхаа бэхжүүлсэн, шинэлэг арга хэмжээг санаачилан хэрэгжүүлсэн жил болж өнгөрлөө.

Энэ бүх үр дүнд хүрэхэд үргэлж дэмжиж хамтран ажилладаг Швейцарын хөгжлийн агентлаг, Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Хотын засаглалыг сайжруулах төслийн нэгж, нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын нийт удирдлага, албан хаагчид, төвийн сургагч багш нар болон хамтран ажилладаг бусад байгууллага, хувь хүмүүстээ гүн талархал илэрхийлье.

Бидний хамтдаа хүрсэн өнөөдрийн үр дүн жилээс жилд улам бэхжиж, Төрийн албаны шинэчлэлийг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх, төрийн үйлчилгээнд шинэ соёл, стандартыг нэвтрүүлэх, хүн төвтэй төрийн үйлчилгээг бий болгоход бодит хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлье.

ХҮНДЭТГЭСЭН:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВИЙН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.ОЮУНЧИМЭГ



**НИЙСЛЭЛИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ**


НИЙСЛЭЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төв (хуучин нэрээр Нийслэлийн Сургалт, судалгааны төв) нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн сан хамтран хэрэгжүүлж буй Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд 2017 онд байгуулагдсан.

2018 онд “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, НИТХ-ын 2019 оны 21/03 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрт тусгагдсаны дагуу НХНХТ нь нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх замаар иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх ЧАДАВХ бүхий төрийн албыг бэхжүүлэх зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Үндсэн үйл ажиллагаа



Сургалт



Зөвлөх үйлчилгээ



Судалгаа, шинжилгээ

АЛСЫН ХАРАА

Төрийн албаны манлайлагчдыг бэлтгэдэг орчин цагийн мэргэшсэн сургалтын байгууллага байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Ур чадварыг тасралтгүй хөгжүүлж эерэг хандлагыг төлөвшүүлэх замаар төрийн бүтээмж, үйлчилгээг нийгмийн шаардлагад нийцүүлэн хүргэх албан хаагчийг бэлтгэнэ.

ҮНЭТ ЗҮЙЛ

- Тасралтгүй суралцагч
- Шинийг эрэлхийлэгч
- Хамтдаа бүтээгч

УРИА

Чадварлаг ажилтан Хотын ирээдүй

ХӨГЖЛИЙН ЗАМНАЛ

2017

Нийслэлийн Сургалт, судалгааны төв үүсэн байгуулагдав.
Чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн загварыг боловсруулав.
Хорооны албан хаагчдад зориулсан сургалтын гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулав.

2018

Чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг боловсруулав.
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан сэдэвчилсэн сургалтын гарын авлагуудыг боловсруулж, сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж эхлэв.

2019

НИТХ-ын 21/03 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр” батлагдав.
НССТ-ийн урт болон богино хугацааны хөгжлийн зураглалыг боловсруулав.
Сургалтын үйл ажиллагаанд харилцан суралцах арга зүйг нэвтрүүлэв.
Цахим сургалтын системийг хөгжүүлэв.

2020

НССТ-ийн үйл ажиллагаанд Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.
“Харилцан суралцах арга зүйн форум”-ыг амжилттай зохион байгуулав.
Сургалтуудыг цахим хэлбэрт хөрвүүлж эхлэв.

2021

Хамтын ажиллагааг өргөжүүлж, Удирдлагын академитай хамтарсан сургалт зохион байгуулах гэрээ байгуулав.
Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 болон Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг тус тус нэвтрүүлэв.

2022

Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв болж өргөжив.

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах үйл ажиллагаа нь нийслэлийн төдийгүй улсын хэмжээний томоохон хөтөлбөрүүд, урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан чухал зорилтуудын нэг юм. НХНХТ нь нийслэлийн хэмжээнд энэ чиглэлийн зорилтыг тогтвортой хэрэгжүүлэх нэгж болон байгуулагдсанаараа онцлогтой.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

- 5.4.12. Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай, тасралтгүй сургалтын тогтолцоог төлөвшүүлнэ.
- 5.4.13. Төрийн албаны сургалтын байгууллагын сургалт - судалгааны материаллаг орчин, хүний нөөц, технологи, арга зүйн чадавхыг бэхжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх шинэчлэл хийнэ.
- 5.4.14. Төрийн албаны сургалтад мэдээллийн технологид суурилсан олон хувилбарт аргуудыг нэвтрүүлнэ. Танхимын сургалтаас гадна цахим болон зайн сургалт, ажлын байранд сургах, цахим сургалтыг төрийн албаны орчин үеийн шаардлагад нийцүүлэн оновчтой ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

- 4.2.6. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

- 5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

- 4.2.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтцийг бий болгоно.
- 4.2.3.1. Нийслэлийн Сургалт, судалгааны төвийн чадавхыг бэхжүүлнэ.
- 4.2.3.2. Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Улаанбаатар хоттой ах дүүгийн болон Найрамдалт харилцаат хотуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр 2019

Зорилго

“Нийгмийн хэрэгцээ шаардлагыг мэдэрч, төрөлх хотоо хөгжүүлэх, дэлхийн хөгжилтэй эн зэрэгцэх чадвартай” мэргэжилтнийг бэлтгэх замаар нийслэл Улаанбаатар хотыг шинжлэх ухаанч, судалгаа шинжилгээнд суурилсан, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлсэн хот болгоход оршино.


НЗДТГ-ын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2021-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр

- 3.1.2. Нийслэлийн Сургалт, судалгааны төвийн үндсэн болон сэдэвчилсэн сургалт

НИЙСЛЭЛИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

НХНХТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 2021 (ТООГООР)

Зохион байгуулсан сургалтын тоо



311

Сургалтын хэлбэр:

Цахим



284

Танхим



27

Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо

Эрэгтэй
31%



Эмэгтэй
69%

6692

Зохион байгуулсан сургалтын төрөл



25

Цахим сургалтын тоо:



8

Сургалтын гарын авлагын тоо



28

Сургагч багшийн тоо

Эрэгтэй
21%



Эмэгтэй
79%

53

Цахим сургалтад хамрагдагчдын тоо



5887

Сургалтад хамрагдсан албан хаагчдын хувь, зорилтот бүлгээр



Хороо
33%



Агентлаг
34%



НЗДТГ
6%



Дүүрэг
18%



ОНӨААТҮГ
6%



УБЗАА
3%

НХНХТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 ОНЫ ГОЛ ҮР ДҮН

Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэгч байгууллага болж гэрчилгээгээ гардан авлаа.

НХНХТ нь Монгол Улсын төдийгүй олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх, байнга тасралтгүй сайжрах, тогтвортой байдлаа хангахын тулд албан бус богино хугацааны сургалтын дизайн боловсруулах, удирдан зохион байгуулах үйл ажиллагаандаа Олон улсын Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартуудыг хэрэгжүүлэн, нэвтрүүлэхээр ажилласны үр дүнд 2021 оны 12 дугаар сард Баталгаажуулалтын гэрчилгээгээ гардан авлаа.

Монгол Улсын хэмжээнд боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн “Анхны төрийн байгууллага” болсон нь томоохон амжилт байлаа.

Төвийн үйл ажиллагаанд олон улсын стандарт нэвтрүүлэх нь урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, “хүн” төвтэй удирдлагаас “процесс” төвтэй удирдлагад шилжсэнээр төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөнөөс үл хамааран үйл ажиллагааны процесс хэвийн үргэлжлэх, процессыг тасралтгүй сайжруулах, төрийн албан хаагчдад чанартай мэдлэг, дадал, ур чадвар олгох чухал ач холбогдолтой юм.

Цахим сургалтын тоог нэмэгдүүлж, агуулга хөгжүүлэв.

Технологийн үсрэнгүй хөгжил, дижитал шилжилт, Ковид-19 цар тахал зэрэг цаг үеийн сорилтыг даван гарах арга замыг эрэлхийлж, цахимаар сургалт зохион байгуулах, богино хугацаанд цахим сургалтын платформыг хөгжүүлж, сургалтуудыг цахим хэлбэрт хөрвүүлэх, цахим сургалтын агуулгыг хөгжүүлэх, сургагч багш нараа цахим сургалтыг үр дүнтэй заахад сургаж бэлтгэх, сургалтын үйл ажиллагаандаа технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх зэргээр шинэ, таамаглашгүй цаг үеийн нөхцөл байдалд уян хатан дасан зохицож, дижитал шилжилтэд хөл нийлүүлэн алхаж байна.

2021 онд Хороодын Засаг даргын үндсэн сургалт, Төрийн архив, албан хэрэг хөтлөлт, Харилцан суралцах арга зүй, Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, Манлайлал зэрэг 5 сургалтыг цахим хэлбэрт хөрвүүлээ.

ННЗБ-ийн албан хаагчдын дунд “Мэтгэлцээний анхдугаар тэмцээн”-г зохион байгуулав.

ННЗБ-ын албан хаагчдын ур чадварыг тасралтгүй хөгжүүлж, хандлага идэвхийг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээнд соёл стандартыг нийгмийн шаардлагад нийцсэн түвшинд хүргэх нь НХНХТ-ийн эрхэм зорилго билээ. НХНХТ нь Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 382 жилийн ойн өдрийг угтан албан хаагчдын

идэвх, оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор Мэтгэлцээний анхдугаар тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, хэрэгжүүлэгч агентлагуудын дунд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 24 баг оролцсон ба хэсгийн тоглолт, хасагдах шатны тоглолт, хагас шигшээ, аваргын төлөөх тоглолтууд явагдаж албан хаагчид цаг үеийн асуудалд шийдэл гаргахад оюун ухаан, ур чадвараа уралдуулан өрсөлдлөө.

Төвийн хүний нөөцийг чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэв.

ХНХТ хүний нөөцөө чадавхжуулж, үйл ажиллагаагаа илүү өргөжүүлэхийн тулд төвийн албан хаагчид, сургагч багш нараа сургах, хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байна. Хүний нөөцийн ур чадварыг тодорхойлж, үнэлгээ хийн, чадамжийн тогтолцоог боловсруулсан. Энэхүү ур чадварын шаардлага, чадамжийн тогтолцоонд үндэслэн хүний нөөцөө сургаж хөгжүүлэх, чадавхжуулах зорилготой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 онд төвийн нийт албан хаагчид, сургагч багш нарын цахим сургалтын ур чадварыг дээшлүүлэх, заах арга зүйг сайжруулах, техник ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр “Багш хөгжлийн цаг”, “Сургагч багш бэлтгэх сургалт” “Moodle систем дээр сургалт удирдах арга зүй”, “Шууд онлайн сургалтыг үр дүнтэй зохион байгуулах”, “Сургалтыг үр дүнтэй заах арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгох нь” зэрэг олон сургалт, арга хэмжээг зохион байгууллаа.

Харилцан суралцах арга зүйн платформыг хөгжүүлэв.

Аливаа байгууллага, албан хаагч бүрт тодорхой хэмжээний хуримтлуулсан мэдлэг, сайн туршлага байдаг. Энэхүү сайн туршлагыг нээн илрүүлэх, бусдад хуваалцах, түгээн дэлгэрүүлэх нь Харилцан суралцах арга зүй (ХСАЗ)-н зорилго юм. НХНХТ нь 2021 онд хороодын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ХСАЗ-н manaikhoroо.mn платформыг хөгжүүлж, 144 сайн туршлагыг платформд байршуулав. Ингэснээр хороодын албан хаагчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран харилцан суралцах боломжийг бий болголоо. Цаашид Харилцан суралцах арга зүйн “Шилдэг хороо”-г шалгаруулах улсын уралдааныг зохион байгуулах санал санаачилга гарган ажиллаж байна.


Хамтын ажиллагааг өргөжүүлж, төвийн чадавхыг бэхжүүлэв.

НССТ нь төрийн албан хаагчдад зориулсан сургалтын нэгдсэн, цогц систем бий болгох зорилгынхоо хүрээнд сургалтуудын уялдаа холбоог хангах, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарч байна. Энэ хүрээнд 2021 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг сургах, тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр Удирдлагын академи, Швейцарын хөгжлийн агентлаг, Азийн сан, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, бусад үндэсний болон олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, их дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, төрийн албан хаагчдад зориулсан сургалтуудын уялдаа холбоог сайжруулахад ахиц гаргалаа. Ялангуяа Удирдлагын академитай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, сургагч багш бэлтгэж, сургалтын хөтөлбөр боловсруулж, “Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт”-г хамтран зохион байгууллаа. НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай сургалтын хөтөлбөр боловсруулах, цахим хэлбэрт шилжүүлэх, цахим сургалтыг платформд байршуулах, цахим сургалт зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НХНХТ нь Чадавх бэхжүүлэх хөтөлбөрт тодорхойлсноор сургалтын үйл ажиллагааны бүхий л үе шатуудыг системчилсэн загварын дагуу хэрэгжүүлж байна. Энэ нь олон улсад ашиглагддаг сургалтын уян хатан загвар болох ADDIE загвартай уялддаг.

НХНХТ-ийн сургалтын системчилсэн загвар



1. Сургалтын хэрэгцээний үнэлгээ хийх

НХНХТ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын сургалтын хэрэгцээний үнэлгээний судалгааг жил бүр зохион байгуулж, судалгааны үр дүнд үндэслэн сургалтын агуулга боловсруулах, түүнийг сайжруулах, сургалтын жилийн төлөвлөгөө боловсруулах ажлуудыг гүйцэтгэдэг.

Сургалтын хэрэгцээний үнэлгээний судалгаанд хамрагдсан ННЗБ-ын албан хаагчдын тоо

- 2018 он - 1208 албан хаагч
- 2019 он - 2700 албан хаагч
- 2020 он - 362 албан хаагч
- 2021 он - 2315 албан хаагч

Мөн 2019 онд сургалтын хэрэгцээний судалгаа, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн ННЗБ-ын албан хаагчдын Чадамжийн тогтолцоог боловсруулж, Төрийн албан хаагчдад тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлсон.

2. Сургалтын дизайн боловсруулах

Сургалтын хэрэгцээний үнэлгээний үр дүнд үндэслэн сургалтын зорилтот бүлгийг тодорхойлох, сургалтын агуулгын хүрээг боловсруулж, улмаар анхан шатны болон баталгаажуулах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах замаар сургалтын агуулга, хугацаа, заах арга зүй гэх мэт сургалтын дизайныг боловсруулдаг. Сургалтын дизайн боловсруулах хэлэлцүүлгүүд нь сургалтын зорилтот бүлгүүдийн оролцоотой зохион байгуулагддаг.

НХНХТ-ийн сургалтын зорилтот бүлэг нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид буюу

- НЗДТГ-ын албан хаагчид;
- УБЗАА-ын албан хаагчид;
- Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчид;
- Дүүрэг, хороодын албан хаагчид;
- НХНХТ-ийн сургагч багш нар юм.

3. Сургалтын агуулга, аргачлал боловсруулах



Сургалтын дизайн боловсруулах шатанд хөгжүүлсэн сургалтын агуулгыг энэхүү шатанд сайжруулж, эцэслэн боловсруулдаг. Ингэхдээ сургалтын агуулгаар сургагч багш нарыг тусгайлан бэлтгэх, туршилтын сургалтуудыг зохион байгуулах замаар сургалтын агуулгыг сайжруулдаг.



Сургагч багш бэлтгэх сургалт

Тухайн сургалтын агуулга, арга зүйг төвийн гэрээт болон үндсэн сургагч багш нарт эзэмшүүлэх сургалт



Туршилт сургалт

Сургалтын агуулгаар сургагч багш нар хичээл зааж турших сургалт



Сургалтын агуулга, аргачлалыг сайжруулж боловсруулах

4. Сургалтыг зохион байгуулах

НХНХТ нь сургалтын жилийн төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулдаг. Ингэхдээ төрөл бүрийн арга хэлбэрийг ашиглан, суралцагчдын сонирхлыг татахуйц, оролцоог хангасан, хувь хүн өөрийн чадварыг нээн илрүүлэх боломжийг бүрдүүлсэн, ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулахыг зорьж байна.

Сургалтыг шаталсан хэлбэр буюу үндсэн, чиглэлийн, мэргэшүүлэх гэж ангилан зохион байгуулдаг.

Үндсэн сургалт	Төрийн албанд анх удаа томилогдож буй нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан төрийн албаны стандартын мэдлэг олгох анхан шатны сургалт
Чиглэлийн сургалт	Албан тушаалын ангилал, зэрэглэл ахих, шилжих, сэлгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх ахисан түвшний сургалт
Мэргэшүүлэх	Ажлын байранд тавигдах тусгай шаардлагыг хангах ур чадвар, чадамжийг эзэмшүүлэх зорилготой мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон удирдах албан тушаалтны сургалт

5. Сургалтын үнэлгээ хийх

НХНХТ нь сургалтын үйл ажиллагааны бүхий л үе шатанд сургалтын үнэлгээ хийж сайжруулдаг. Сургалтын явцад багш нарын ур чадвар, сургалтын агуулга, арга зүйн тохиромжтой байдал, сургалтын орчин зэрэгт хяналт, үнэлгээ хийхийн зэрэгцээ, сургалтын дараах сэтгэл ханамжийн судалгааг тогтмол зохион байгуулдаг. Сургалтын үнэлгээний тусламжтай сургалтын агуулга, арга зүй, орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн, зохион байгуулалтыг сайжруулах, сургагч багш нарыг чадавхжуулах, сургалтын үр дүнг хэмжих боломж бүрдэж байна.

СУРГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

НХНХТ нь 2017-2018 онд хорооны албан хаагчдад зориулсан суурь сургалтуудыг явуулсан бол 2019 оноос эхлэн хороо, дүүрэг, нийслэлийн албан хаагчдад сэдэвчилсэн сургалтуудыг зохион байгуулж эхэлсэн.

Он	Хороо	Дүүрэг	Агентлаг	Албан хаагч	Эмэгтэй	Эрэгтэй	Сургагч багш	Гарын авлага	Цахим сургалтад
2017	152			2903	2564	339	49	5	
2018	152			316	263	53	19	9	
2019	171	9	34	2384	1741	643	62	16	22
2020	17	9	34	2156	1509	647	29	22	110
2021	171	9	34	6692	2075	4617	53	28	5887

2017 оноос хойш нийт 14451 албан хаагч сургалтад хамрагдсан.

2021 онд зохион байгуулсан сургалтууд

	Сургалтын сэдэв	Сургалт зохион байгуулсан тоо	Хамрагдсан албан хаагчдын тоо
1	ERP болон өргөдөл гомдлын систем	37	443
2	MS Excel ахисан шат	4	50
3	MS Excel анхан дунд шат	34	615
4	PowerPoint программ дээр танилцуулга бэлтгэх	4	21
5	Ажлын байрны аюулгүй байдал	2	42
6	Албан бичгийн найруулга зүй	28	464
7	Албан хэрэг хөтлөлт, eDoc	40	618
8	Ашиглалтын хугацааны зардал	4	42
9	Ажлын байр ба баг хамт олны үр дүнтэй харилцаа	10	288
10	Жендэр	4	202
11	Зөрчлийг удирдахуй	8	150
12	Нийслэлийн түүх, захиргааны бүтэц, чиг үүрэг	4	19
13	Өөрчлөлтийн менежмент	8	192
14	Стрессийг удирдахуй	8	114
15	Төрийн албан хаагчийн ёс зүй	34	721
16	Төрийн албан хаагчийн манлайлал	18	210
17	Төслийн удирдлагын үндэс	8	71
18	Манлайлал ба манлайлах ур чадвар	1	31
19	Улс, нийслэлийн хөгжлийн бодлогын суурь үзэл баримтлал	12	358
20	Харилцаа ба Шилжилт хөдөлгөөн	4	1082
21	Харилцан суралцах арга зүй	10	21
22	Хорооны Засаг даргын үндсэн сургалт	2	158
23	Хууль эрх зүйн шинэчлэл	12	414
24	Хүн төвтэй төрийн үйлчилгээ	3	26
25	Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь	12	340
	Нийт	311	6692

СУРГАЛТЫН АГУУЛГА ХӨГЖҮҮЛЭЛТ

НХНХТ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан 28 төрлийн гарын авлага, сургалтын агуулгыг боловсруулаад байна.

2017	Үндсэн сургалт
	• Нийслэлийн хороодын засаг дарга нарт зориулсан сургалтын гарын авлага
	• Нийслэлийн хороодын зохион байгуулагч нарт зориулсан сургалтын гарын авлага
	• Хорооны нийгмийн ажилтанд зориулсан сургалтын гарын авлага
	• Хорооны хэсгийн ахлагч нарт зориулсан сургалтын гарын авлага
	• Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт

2018	Үндсэн сургалт
	• Ажлын байр ба баг хамт олны үр дүнтэй харилцаа
	Чиглэлийн сургалт
	• Хүн төвтэй төрийн үйлчилгээ - Жендерийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээ үзүүлэх нь
	Мэргэшүүлэх сургалт
	• Сургалтын хэрэгцээний үнэлгээ хийх аргачлал • Сургагч багшийн гарын авлага

2019	Чиглэлийн сургалт
	• Судалгааны арга зүй
	• MS Excel программ
	• Төрийн албан хаагчдад зориулсан хууль, эрх зүйн гарын авлага
	• Манлайлал ба манлайлах ур чадвар
	Мэргэшүүлэх сургалт
	• Удирдах ажилтнуудад зориулсан Менежментийн түвшний манлайлал
	• Бизнес процессын дахин загварчлал
	• Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй
	• Төслийн ашиглалтын хугацааны зардал • Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг тооцох


2020	Үндсэн сургалт
	• Архив, албан хэрэг хөтлөлт
	• Нийслэлийн түүх, ННЗБ-уудын бүтэц, чиг үүрэг
	• Төрийн албан хаагчийн манлайлал анлайлал
	Чиглэлийн сургалт
	• Харилцан суралцах арга зүйн сургалтын гарын авлага
	• Гамшиг, онцгой байдлын үед иргэдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь
	Мэргэшүүлэх сургалт
	• Төслийн удирдлагын үндэс • Сургагч багш нарт зориулсан гарын авлага

2021	Үндсэн сургалт
	· Хорооны засаг даргад зориулсан үндсэн сургалтын гарын авлага
	Чиглэлийн сургалт
	· Хүн төвтэй төрийн үйлчилгээ сургалтын гарын авлага
	· Манлайлал ба манлайлах ур чадвар
	· MS Excel ахисан шат
	Мэргэшүүлэх сургалт
	· Судалгааны арга зүй
	· Дотоодын шилжилт хөдөлгөөний ойлгож удирдахад төрийн үйлчилгээ чухал болох нь

СУРГАЛТЫН АРГА

Сургалтын аргын онцлог

НХНХТ нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ олон улсад ашиглагддаг, үр дүнтэй сургалтын зарчим болох 70:20:10 зарчмыг баримталж байна. Энэ зарчмын дагуу суралцагч мэдлэгийн 10 хувийг танхимын болон цахим сургалтаас авах ба 20 хувийг бусадтай хамтран, харилцан суралцах замаар, 70 хувийг дадлага хийх, ажлын байран дээр хэрэгжүүлэх замаар олж авснаар сургалтын үр дүн илүү өндөр байдаг.



НХНХТ нь сургалтын хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дээрх зарчмын дагуу суралцагчдад онолын мэдлэг олгохоос гадна түүнийг бататгах харилцан суралцах арга зүйг нэвтрүүлэх, сургалтаас олж авсан мэдлэгийг ажлын байран дээр хэрэгжүүлэхэд дэмжих зэрэгт анхааран ажиллаж байна.

СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА

НХНХТ нь сургалтын зорилго, онцлог, зорилтот бүлгээс хамааруулан сургалтын зохион байгуулалтын 4 төрлийн аргаас сонгон хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Танхимын сургалт
2. Шууд онлайн сургалт
3. Шууд бус онлайн сургалт
4. Харилцан суралцах арга зүй

Танхимын сургалт

НХНХТ нь компьютер, тоног төхөөрөмж бүхий 15-30 хүний багтаамжтай хоёр сургалтын танхим болон 35 суурин компьютер бүхий лабораторид танхимын сургалтуудыг зохион байгуулж байна.

Шууд онлайн сургалт

НХНХТ нь сургалтын хүртээмж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим сургалтын арга хэлбэрийг үе шаттайгаар хөгжүүлж байна. Цахим сургалтыг шууд болон шууд бус онлайн хэлбэрээр зохион байгуулдаг. 2021 онд төвийн 2 зүүм эрхээр 130 удаагийн шууд онлайн сургалтыг зохион байгуулсан.

Шууд бус онлайн сургалт

Шууд бус онлайн сургалтыг зохион байгуулахдаа олон улсад ашиглагддаг сургалтын нээлттэй платформ болох MOODLE (Modular Object Oriented Dynamic Learning Environment) системийг ашиглаж байна. 2019 онд “Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй”, 2020 онд “Төслийн ашиглалтын хугацааны зардал”, “Хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалтын агуулгыг цахим хэлбэрт хөрвүүлж, нийт 132 албан хаагчийг цахим сургалтад хамруулаад байна. 2021 онд 6 сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж MOODLE системд байршуулсан.

Харилцан суралцах арга зүй


Харилцан суралцах арга зүй нь практик үр дүнд суурилсан, ижил түвшний байгууллага, албан хаагчид хоорондоо харилцан бие биеэсээ суралцаж, сайн туршлагыг солилцох замаар өөрсдийн чадавхыг бэхжүүлж, тасралтгүй сайжрах, хөгжих арга барил юм.

Харилцан суралцах арга зүйн зорилго нь

- ННЗБ-ын чадавхыг бэхжүүлэх;
- Сайн туршлагыг дэлгэрүүлэх;
- ННЗБ-ын харилцааг хөгжүүлэх платформ бий болгох;
- Тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх замаар салбарын болон үндэсний хэмжээний бодлогод нөлөө үзүүлэх юм.

Харилцан суралцах арга зүйн платформ

Харилцан суралцах арга зүйг ННЗБ-уудын дунд улам хөгжүүлэх, дэлгэрүүлэх зорилгоор 2020 оны 9 дүгээр сард нийслэлийн хэмжээнд шалгарсан 5, дүүргийн хэмжээнд шалгарсан 27 сайн туршлагыг танилцуулах уулзалт семинарыг “Харилцан суралцах арга зүйн форум-2020” нэртэйгээр амжилттай зохион байгуулсан. Шалгарсан сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх, хороод харилцан суралцах, хамтран хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор manakhoroо.mn платформыг ажиллуулж байна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

2021 онд НХНХТ-ийн албан хаагчид болон сургагч багш нарын сургалтын хэрэгцээнд үндэслэн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан сургалтуудыг төлөвлөж зохион байгуулсан. Цаашид “Үр дүнтэй онлайн сургалт зохион байгуулах нь”, “Сургалтын дизайн ба суралцахуйн дизайн” зэрэг олон улсын хөтөлбөрт төвийн албан хаагч, сургагч багш нараа хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

НХНХТ-ийн албан хаагчид, сургагч багш нарт зориулсан сургалт 2021


- 1 дүгээр сар: Шууд онлайн сургалтыг үр дүнтэй зохион байгуулах бэлтгэлтэй холбоотой сургалтууд
- 2 дугаар сар: Шууд онлайн сургалт удирдах туршилт сургалт
- 3 дугаар сар: Moodle систем дээр сургалт удирдахад бэлтгэх сургалт
- 4 дүгээр сар: Бизнес процесс дахин загварчлал сургалтын сургагч багш бэлтгэх сургалт
Хүн төвтэй төрийн үйлчилгээ сургалтын сургагч багш бэлтгэх сургалт
- 5 дугаар сар: Сургагч багшийн сургалт
- 6, 7 дугаар сар: Харилцан суралцах арга зүйн сургалтууд
- 8 дугаар сар: Дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож удирдахад төрийн үйлчилгээ чухал болох нь сургалтын сургагч багш бэлтгэх сургалт
- 9 дүгээр сар: Hard skill сургалтууд /Excel, PowerPoint, Photoshop/
- 10 дугаар сар: Багш хөгжлийн цаг сургалт, уулзалт
- 11 дүгээр сар: Удирдлагын академитай хамтарсан чиглүүлэх сургалтын “Багш бэлтгэх сургалт”
Судалгааны арга зүй сургалтын сургагч багш бэлтгэх сургалт
- 12 дугаар сар: Сургалтыг үр дүнтэй заах арга зүй сургалт
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгох нь сургалт
Тайлангийн хурал

САНХҮҮЖИЛТ

НХНХТ нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн сан хамтран хэрэгжүүлж буй Хотын засаглалыг сайжруулах төслийн болон НЗДТГ-ын төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

НХНХТ нь ХЗСТ-ийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа эхэлсэн хэдий ч санхүүжилтийн бүтцэд НЗДТГ-ын оролцоо жил ирэх бүр нэмэгдэж буй нь байгууллагын үйл ажиллагааны ач холбогдол хийгээд цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах баталгаа болж байна.

Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвийн санхүүжилт



2021 онд НЗДТГ-аас Хүний нөөцийн хөгжлийн төвд 400,0 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс 168,822,238 төгрөг (42%)-ийн төсвийг зарцуулсан байна.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтрагч түншүүд

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
- Олон улсын байгууллагууд
- Их, дээд сургуулиуд
- Төрийн бус байгууллагууд
- Хувийн хэвшлийн байгууллагууд

ОНЦЛОХ ТҮНШҮҮД

Удирдлагын академи

Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2019 оны “Сургалтын агуулга, хөтөлбөр батлах тухай” 299 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн харьяа бүх шатны байгууллагуудын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд богино хугацааны сургалтыг хамтран зохион байгуулах,

НХНХТ-ийн сургагч багш нарыг үнэлэх, чадавхжуулах, судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээний чиглэлээр Удирдлагын академи, Азийн сантай хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд 2021 онд сургагч багшийг бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, хамтарсан сургалт зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлээд байна.

Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА)

Швейцарын хөгжлийн агентлаг нь Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийнхөө хүрээнд 2015 оноос НХНХТ-ийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэмжин ажиллаж буй гол санхүүжүүлэгч байгууллага юм.

Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

НЗДТГ, Азийн сан хамтран 2015 оноос Хотын засаглалыг сайжруулах төслийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь ШХА-ын Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн хүрээнд НЗДТГ-ын чадавхыг бэхжүүлэх замаар төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Төсөл нь, нэгдүгээрт, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх байнгын тогтолцоог бий болгож бэхжүүлэх, төрийн албанд тасралтгүй суралцах соёлыг төлөвшүүлэх; хоёрдугаарт, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах; гуравдугаарт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт өгсөн иргэдийн саналыг шийдвэр гаргах явцад тусгаснаар иргэдийн оролцоог төсвийн төлөвлөлтөд нэмэгдүүлэх гэсэн гурван зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, НХНХТ-өөр дамжуулан хэрэгжүүлж байна.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-ийн Монгол улсад барилгын эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх төсөл

Төслийн хүрээнд 2018 онд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бодлого төлөвлөгч мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын агуулгыг боловсруулж, 2019 онд “Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй”, 2020 онд “Төслийн ашиглалтын хугацааны зардал”, “Хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалтын агуулгыг цахим хэлбэрт хөрвүүлж, шууд бус онлайн сургалтууд зохион байгуулсан.

Мөн 2020 онд “Төслийн удирдлагын үндэс” сургалтын агуулгыг олон улсын төслийн удирдлагын Project Management Body of Knowledge (PMBOK) стандартын дагуу нийслэлийн онцлогт нийцүүлэн боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэсэн.

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй НҮБ-ын Шилжих хөдөлгөөний байгууллагын Дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах төсөл

Түүнчлэн хорооны Засаг дарга нарт зориулсан сургалт, Манлайллын сургалтын агуулгад “Шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” сэдэвт дэд агуулгыг боловсруулж, нэмэлтээр тусгасан. Мөн “Дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож удирдахад төрийн үйлчилгээ чухал болох нь” сургалтын гарын авлагыг боловсруулж, цахим хэлбэрт хөрвүүлж байна. Цаашид энэхүү сургалтад 1000 албан хаагчийг хамруулахаар төлөвлөөд байна. Түүнчлэн Нийслэлийн иргэд болон гадаадаас шилжин суурьшиж буй иргэдэд зориулсан жижиг бизнес эрхлэхэд чиглүүлэх сургалтуудыг төвийн цахим системд нийтэд нээлттэй байршуулж хамтран ажиллаж байна.

**2022 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ
3 ЗОРИЛГО БА
ХҮЛЭЭГДЭЖ БУЙ
ҮР ДҮН**

1. Өрсөлдөхүйц сургалтын хөтөлбөртэй болно.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын ажлын байранд тавигдаж буй ур чадварын шаардлагад тохирсон сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулж судалгааны үр дүнд суурилан сургалтын агуулгыг сайжруулан ажиллана. Үүний зэрэгцээ олон улсын сургалтын хөтөлбөрийн эрх авах, сургалт явуулах сургагч багш бэлтгэх замаар өрсөлдөхүйц сургалтын хөтөлбөртэй болж төвийн чадавхыг бэхжүүлнэ. 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ажлын байрны болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг, танхимаар болон цахимаар зохион байгуулж нийт 6044 албан хаагчийг сургалтад хамруулахаар төлөвлөж байна.

2. Албан хаагчдын мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэхүй, хандлага харилцааг хөгжүүлэх хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлнэ.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын хэрэгцээнд суурилсан сургалтын төлөвлөгөө, хуваарь боловсруулах, хэрэгжүүлэх, ННЗБ-ын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн болон сургалт хариуцсан ажилтнуудад сургалт, уулзалт зохион байгуулах зэргээр албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлнэ. Засаг даргын нэрэмжит Нийслэл Академи, ННЗБ-ын албан хаагчдын Нэгдсэн алхалт, Мэтгэлцээний тэмцээн, Кэйс бичих уралдаан, Менторшип хөтөлбөр, Нийтийн албаны хүний нөөцийн чуулган зэрэг албан хаагчдын хандлага, идэвхийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Сургалтын орчин, нөхцөл бололцоог сайжруулна.

НХНХТ-ийн сургалтын танхим болох HUB Innovation center-ийн 266 м2 талбай бүхий анги танхимыг Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын дагуу тохижуулж сургалтын орчинг сайжруулна. Шууд бус онлайн сургалтын вэб платформ хөгжүүлж, цахим сургалтын тоог нэмэгдүүлж, чанарыг сайжруулан ННЗБ-ын албан хаагчид ажлын байран дээрээ ур чадвараа хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. Дотоод мэдээллийн систем, байгууллагын цахим мэдлэгийн санг хөгжүүлнэ. Сургалтын өрөө танхим түрээслэх, захиалгат сургалт зохион байгуулах зэргээр санхүүгийн чадавхаа нэмэгдүүлнэ. Төвийн албан хаагчид, сургагч багш нарын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Бээжингийн гудамж, Нийслэлийн
төр захиргааны 5-р байр, Улаанбаатар театр,
2 давхар, 207 тоот
+976 11 7011 9900
info@hrdc.ulaanbaatar.edu.mn
hrdc.ulaanbaatar.mn